МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН САЛБАР ДАХЬ ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТЫН ЗОХИЦУУЛАЛТ (МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА)

Судалгааны төрөл:	**Мэдээлэл, лавлагаа**
Судалгааны код:	**СТ-25/420**
Хугацаа:	**2025.10.27**

ЗАХИАЛАГЧ:	УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан
Хянасан:	ПСХХ–ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	Нийгмийн судалгааны хэсгийн эрхлэгч Э.Дашзэгвэ
Судлаач:	Нийгмийн судалгааны хэсгийн референт Р.Оргилмаа

Улаанбаатар хот
2025

АГУУЛГА

АГУУЛГА 2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 2
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 2
УДИРТГАЛ 3
НЭГ. ДҮРСЛЭХ УРЛАГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ 4
ХОЁР. УРЛАГИЙН БҮТЭЭЛИЙГ СОЁЛЫН ӨВД БҮРТГЭХ, УЛСЫН БОЛОН НИЙТИЙН САН ХӨМРӨГТ ХУДАЛДАН АВАХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ. 11
ГУРАВ. ДҮРСЛЭХ УРЛАГИЙН БҮТЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ 16
СУДАЛГААНЫ ҮР ДҮН 18
НОМ ЗҮЙ 20

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Урлагийн бүтээлийн дахин борлуулалтаас уран бүтээлч хувь хүртэх эрхийн зохицуулалт 7
Хүснэгт 2. Урлагийн бүтээл худалдан авах эрх зүйн зохицуулалт, санхүүжилт 12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс

УДИРТГАЛ

“Дүрслэх урлагийн салбар дахь зохиогчийн эрхийн хамгаалалтын зохицуулалт” мэдээлэл, лавлагааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Дүрслэх урлагийн салбарын хууль, тогтоомжийг боловсронгуй болгох, зохиогчийн эрхийн хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд гадаадын таван улсын дүрслэх урлагийн салбарын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Мэдээлэл, лавлагаанд Австралийн Холбооны Улс (Австрали), Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Герман), Бүгд Найрамдах Солонгос Улс (Өмнөд Солонгос), Япон Улсын дүрслэх урлагийн салбарын эрх зүйн зохицуулалт, уран бүтээлчийн эрх ашгийг хамгаалах талаар хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ болон урлагийн бүтээлийг соёлын өвд бүртгэх, улсын болон нийтийн сан хөмрөгт худалдан авах, хадгалах, хамгаалах зэрэг асуудлыг авч үзэв. Улс бүрийн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг харьцуулан, ижил төстэй болон онцлог шинжийг тодорхойлж, зохиогчийн буюу уран бүтээлчийн эрх, урлагийн бүтээлийн дахин борлуулалтаас хувь хүртэх эрх, татварын хөнгөлөлт, урамшууллын дэмжлэг, урлагийн бүтээлийг соёлын өвд бүртгэхэд тавигдах шалгуур, улсын болон нийтийн сан хөмрөгт урлагийн бүтээл худалдан авах, хадгалах, хамгаалах зохицуулалт, үүнд экспорт, импортын хяналт, дүрслэх урлагийн бүтээлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг хэрхэн зохицуулдаг талаарх асуудлыг тус тус тоймлон авч үзлээ.

Судалгааны ажлын бүтэц: *Мэдээлэл, лавлагаа гурван хэсэгтэй. Үүнд:*

1. Дүрслэх урлагийн салбарын уран бүтээлчдийн эрх ашгийг хамгаалах;
2. Уран бүтээлийг соёлын өвд бүртгэх, улсын болон нийтийн сан хөмрөгт худалдан авах, хадгалах, хамгаалах;
3. Дүрслэх урлагийн бүтээлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх зохицуулалт.

Судалгааны арга зүй: Мэдээлэл, лавлагааг тухайн улсын дүрслэх урлагийн салбарыг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, мэдээлэл, лавлагааны удирдамжид заасан чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Түлхүүр үг: Дүрслэх урлагийн салбар, уран бүтээлчийн эрх

Key words: Visual art, artist’s rights

НЭГ. ДҮРСЛЭХ УРЛАГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дүрслэх урлагийн салбар нь уран бүтээлчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, соёлын өвийг хадгалан хамгаалах, олон нийтийн хүртээл болгох, мөн тэдгээрийг гэмт хэрэг, хууль бус худалдаанаас сэргийлэхэд чиглэсэн олон талт эрх зүйн зохицуулалттай байдаг. Дүрслэх урлагийн салбарын эрх зүйн зохицуулалтын орчин нь тухайн улсын соёлын бодлого, оюуны өмчийн хамгаалалт, уран бүтээлчдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа, соёлын өвийн хууль тогтоомж зэргийн нийлбэр цогц юм. Энэ мэдээлэл, лавлагаагаар Австралийн Холбооны Улс (Австрали), Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Герман), Бүгд Найрамдах Солонгос Улс (Өмнөд Солонгос) болон Япон Улсын дүрслэх урлагийн салбарын эрх зүйн зохицуулалтыг тоймлон авч үзлээ.

Олон улсад уран зохиол, урлагийн бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалах суурь гэрээ буюу “Бернийн конвенц”-ыг 1886 онд батлан, даган мөрдөж байна (WIPO, n.d.). Конвенцод нэгдэн орсон улс орнууд өөр улсын уран бүтээлчийн бүтээлийг өөрийн орны уран бүтээлчийн адил түвшинд хамгаалах үүрэг хүлээдэг. Судалгаанд авсан улс орнуудын хууль тогтоомжид дүрслэх урлагийн бүтээлийг хамгаалах ерөнхий зохицуулалт нь Бернийн конвенцын зарчимд үндэслэсэн нийтлэг суурьтай ч, нарийвчилсан зохицуулалт нь тухайн улс орны эрх зүйн тогтолцоо, соёлын бодлогоос хамааран харилцан адилгүй байна.

Судалгаанд авсан орнуудаас Өмнөд Солонгос Улс дүрслэх урлагийн салбарын асуудлыг хамарсан “Дүрслэх урлагийг дэмжих тухай”[1] бие даасан хуультай бол зарим улс орнууд нь ерөнхий соёл урлаг, оюуны өмчийн хуулиудаар (Герман, Япон) тус салбарын харилцааг зохицуулж байна. Харин Австрали Улсын хувьд дүрслэх урлагийн салбар дахь тухайлсан харилцааг зохицуулсан “Дүрслэх урлагийн дахин борлуулалтын эрхийн тухай хууль”[2] хэрэгжиж байгаа бол АНУ-ын хувьд Нэгдсэн Улсын Зохиогчийн эрхийн тухай хуульд[3] нэмэлтээр “Дүрслэх урлагийн уран бүтээлчдийн эрхийн тухай хууль” (§106A)-ийг баталж, дүрслэх урлагийн уран бүтээлд хамаарах зохиогчийн эдийн бус эрхийг тусгайлан тогтоосон байна.

Эдгээрээс **Өмнөд Солонгос Улс** нь соёл, урлагийн салбарт хамаарах хууль эрх зүйн орчноо сүүлийн 10 жилийн хугацаанд эрчимтэй шинэчилж, соёл урлагийн зах зээлээ зохицуулах, уран бүтээлчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлд хуулиудыг батлан гаргасан байна. Тус улс 2023 оны 07 дугаар сард соёл урлагийн зах зээл, ялангуяа дүрслэх урлагийн худалдаа, арилжааг зохицуулах анхны бие даасан “Дүрслэх урлагийн салбарыг дэмжих тухай хууль”-ийг баталж, тус улсын дүрслэх урлагийн зах зээлд тогтсон зөвхөн гэрээний харилцаагаар явагддаг байсан олон асуудлыг хуульчилсан байна. Тухайлбал, уран бүтээлч, захиалагч болон галерей хоорондын гэрээ нь ил тод, шударга, стандартад нийцсэн байх (§17), галерей, дуудлага худалдааны газраас урлагийн бүтээл худалдан авагчдад бүтээлийн баталгаат байдлыг нотолсон гэрчилгээ, мэдээлэл өгөх үүрэгтэй болохыг хуульчилсан (§16). Мөн уран бүтээлчдийн бүтээлийг дахин борлуулахад тухайн уран бүтээлч тодорхой хувь хүртэх эрхийг хуульчилсан байна (§24(1)). Түүнчлэн урлагийн бүтээлийн дилер, зуучлал эрхлэгчид Засгийн газарт бүртгүүлэн зөвшөөрөл

[1] Өмнөд Солонгос, Art Promotion Act 2023. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=68295&key=17&type=part .
[2] Австрали, Resale Royalty Right for Visual Artists Act 2009. Хандах: https://www.legislation.gov.au/C2009A00125/2024-10-14/2024-10-14/text/original/epub/OEBPS/document_1/document_1.html
[3] АНУ, 17 U.S.C. §106A. Хандах: https://www.law.cornell.edu/uscode/text/17/106A .

авах “Урлагийн бизнесийн бүртгэлийн систем” нэвтрүүлэхээр заасан нь дүрслэх урлагийн зах зээлийг ил тод, хяналттай болгох алхам болжээ (§18). Энэ хууль нь уран бүтээлчийн эрхийг хамгаалан, шударга бусаар буюу бага үнээр бүтээлээ үнэлүүлэх, худалдаалах эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой урлагийн зах зээлийн харилцааны ерөнхий хууль болсон байна.

Уран бүтээлчдийн эрх ашгийг хамгаалах

Дүрслэх урлагийн салбарын уран бүтээлчдийн олон улсын суурь эрх нь “Бернийн конвенц”, Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас баталсан “Зохиогчийн эрхийн гэрээ” (WIPO, 1996), Дэлхийн Худалдааны Байгууллагаас баталсан “Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой талуудын хэлэлцээр” (WIPO, 2017) зэрэг баримт бичгүүдэд тусгалаа олсон байна.

Уран бүтээлчид олон улсад түгээмэл хүлээн зөвшөөрөгддөг эдийн буюу онцгой эрх (бүтээлийг ашиглахыг зөвшөөрөх/ хориглох - economic/exclusive rights) болон эдийн бус буюу ёс суртахууны эрх (нэр дурдуулах, бүтээлийн бүрэн бүтэн байдлыг хамгаалуулах - moral rights)-ийг нийтлэгээр эзэмшдэг. Эдийн болон эдийн бус эрхүүд нь зохиогчийн эрхэд хамаарах бөгөөд судалгаанд хамруулсан улс орнуудад зохиогчийн эрхийн хуулиар хамгаалагддаг. Үүний сацуу эх бүтээлийг зах зээл дээр дахин борлуулах бүрд зохиогч (эсвэл өв залгамжлагч) борлуулалтын үнийн хувь авах дахин борлуулалтын эрх (artist’s resale right) -ийг эдэлнэ. Эдгээр эрхүүд нь улс орон бүрийн онцлогоос хамааран харилцан адилгүй хүрээнд хэрэгждэг байна. Дээрх эрхээс онцлог зохицуулалт бүхий эдийн бус (moral rights) болон дахин борлуулалтын эрх (resale right)-ийг авч үзлээ.

Зохиогчийн эдийн бус эрх

Зохиогчийн эдийн бус буюу ёс суртахууны эрхийг Австрали (§193, 195)[4], Герман (§12, 13, 14,)[5] (SKW Schwarz, 2019), Өмнөд Солонгос (§12, 13, 15)[6], Япон (§18, 19, 20)[7] улсад зохиогчид насан туршид нь, үүнээс Герман (§64) болон Япон (§60, 116) улсад зохиогч нас барснаас хойш 70 жил үргэлжлэх хугацаатайгаар хадгалагдах ба бусдад шилжүүлж болохгүй нөхцөлөөр тодорхой хамгаалсан байна.

Харин АНУ-д зөвхөн хязгаарлагдмал хүрээнд буюу дүрслэх урлагийн тодорхой төрлийн бүтээл (уран зураг, уран баримал зэрэг)-д уран бүтээлчийн амьд ахуйд нэрийг хадгалах болон бүтээлийг өөрчлөх, сүйтгэхээс хамгаалах зохиогчийн эдийн бус эрхийг тусгайлан хуульчилсан байна.[8]

[4] Австрали, Copyright amendment (Moral rights) Act 2000. Хандах: https://www.austlii.edu.au/cgi-bin/viewdoc/au/legis/cth/num_act/cara2000342/sch1.html.
[5] Герман, Act on Copyright and Related Rights. Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_urhg/index.html?utm_source.
[6] Өмнөд Солонгос, Copyright Law. Хандах: https://www.copyright.or.kr/eng/laws-and-treaties/copyright-law/chapter02/section03.do?utm_source.
[7] Япон, Copyright Act. Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3379/en.
[8] АНУ, 17 U.S.C. §106A. Хандах: https://www.copyright.gov/title17/title17.pdf.

<u>Урлагийн бүтээлийн дахин борлуулалтаас хүвь хүртэх эрх</u>

Уран бүтээлийн дахин борлуулалтын шимтгэлийн эрх нь “Бернийн конвенц”-оор баталгаажсан хэдий ч энэ эрхийг хэрэгжүүлэх эсэх, хувь хэмжээ, босго, хүчинтэй байх хугацаа зэргийг улс орнууд харилцан ялгаатай тогтоодог.

Уран бүтээлийг анх борлуулснаас хойш зах зээл дээр дахин борлуулахад зохиогч тодорхой хувиар шимтгэл авах эрхийг Австрали Улс “Дүрслэх урлагийн дахин борлуулалтын эрхийн тухай” бие даасан хуулиар, Герман Улс “Зохиогчийн эрхийн тухай хууль”-ийн тодорхой зүйлээр нарийвчлан зохицуулсан байна. Харин Өмнөд Солонгос Улс 2023 онд баталсан “Дүрслэх урлагийн салбарыг дэмжих тухай” хуулийн 3-р бүлгээр зохицуулсан байна. Судалгаанд авсан АНУ болон Япон Улсад энэ асуудлыг хуулиар тусгайлан зохицуулаагүй байна.

Австрали Улс нь “Дүрслэх урлагийн дахин борлуулалтын эрхийн тухай” 2009 онд баталсан бие даасан хуулиар тодорхой үнийн босго хангасан (1,000 Авсрали доллар (AUD)-аас дээш (§10)) бүх уран зураг, баримал зэрэг урлагийн бүтээлийг дахин борлуулах бүрд борлуулалтын үнийн дүнгийн 5%-ийн төлбөр (роялти)-ийг уран бүтээлчид (эсвэл түүний өв залгамжлагчид) олгохоор зохицуулжээ (§18). Энэ эрх нь уран бүтээлчийг нас барснаас хойш 70 жилийн хугацаанд хүчинтэй (§32). Төлбөрийг цуглуулан, уран бүтээлчдэд олгох үйл ажиллагааг Зохиогчийн эрхийн агентлаг хариуцдаг.

Герман Улсын хувьд “Зохиогчийн эрхийн тухай хууль”-ийн 26-р зүйлд уран зураг, баримал, гэрэл зураг зэрэг дүрслэх урлагийн эх бүтээл дахин худалдаалагдах бүрд зохиогчид борлуулалтын үнийн тодорхой хувь төлөхийг заасан. Тухайлбал, дахин борлуулалтын шимтгэл нь татваргүй борлуулалтын үнэ 400 еврогоос дээш тохиолдолд шаталсан журмаар (үнэ өсөх тусам хувь буурах байдлаар 4%-аас 0.25% хүртэл буурна) тооцогдож, нэг борлуулалтад ногдох нийт дүн 12,500 €-аас хэтрэхгүй байхаар хуульчилжээ. Энэ төлбөрийг “Bildkunst зохиогчийн эрхийн хамтын удирдлагын байгууллага” цуглуулж, зохиогчдод хуваарилдаг байна (BildKunst, n.d.).

Өмнөд Солонгос Улсын хувьд 2027 оноос хэрэгжих “Дүрслэх урлагийн салбарыг дэмжих тухай хууль”-аар дүрслэх урлагийн бүтээлийн 5 сая воноос дээш үнэтэй дахин борлуулалтад уран бүтээлч нөхөн төлбөр нэхэмжлэх эрхийн хугацаа уран бүтээлч нас барснаас хойш 30 жил болон гэрээгээр гүйцэтгэсэн бүтээлийн дахин борлуулалтын хувь (§24), нөхөн төлбөрийг цуглуулах, хуваарилах (§25), дүрслэх урлагийн зах зээлд оролцогчдоос мэдээлэл гаргуулах эрх (§26) зэрэг асуудлыг тус тус зохицуулсан байна. Төлбөрийг Соёлын сайдын үүрэг болгосон байгууллагаар дамжуулан цуглуулж, хуваарилахаар хуульд заажээ.

АНУ-д Зохиогчийн эрхийн анхны худалдан авагчийн номлол *(First Sale Doctrine*)-ын дагуу оюуны өмчийн биет бүтээлийг хууль ёсоор худалдан авсан этгээд дараагийн борлуулалтыг чөлөөтэй хийх эрхтэй бөгөөд зохиогчид дахин төлбөр төлөх үүрэг хүлээдэггүй (U.S. Department of Justice Archives, n.d.).

Хүснэгт 1. Урлагийн бүтээлийн дахин борлуулалтаас уран бүтээлч хувь хүртэх эрхийн зохицуулалт

Улс	Хуулийн нэр
Австрали	“Дүрслэх урлагийн дахин борлуулалтын эрхийн тухай хууль” 2009[9]
АНУ	-
Герман	“Зохиогчийн эрх болон холбогдох эрхийн тухай хууль”[10] (§26)
Өмнөд Солонгос	“Дүрслэх урлагийн салбарыг дэмжих тухай хууль” (§24-26)
Япон	-

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

<u>Уран бүтээлчийн эрхийг хамгаалах, дэмжих</u>

Уран бүтээлчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд судалгаанд авсан улс орнууд төрөл бүрийн зохицуулалт, механизмыг тогтоосон байна. Тухайлбал, Герман Улс уран бүтээлчдийн нийгмийн даатгалын хуулиараа дэлхийд тэргүүлэх шийдэл нэвтрүүлсэн бол Өмнөд Солонгос Улс уран бүтээлчийн нийгмийн хамгааллын тухай хуулийг батлан стандарт гэрээг хуульчлан, шударга бус нөхцөлөөс сэргийлэх институцийн суурийг тавьсан байна. Австрали, АНУ, Япон улсууд урлагийн үндэсний сан байгуулан, түүгээрээ дамжуулан тэтгэлэг, хөнгөлөлттэй зээл, тусламж олгодог байна. Мөн Австрали болон АНУ биет урлагийн бүтээлийг нийтийн цуглуулгад бэлэглэх нөхцөлд, Герман, Өмнөд Солонгос, Япон улсад урлаг соёлыг дэмжих хандивт татварын давуу нөхцөл тус тус олгодог байна.

Австрали Улс уран бүтээлчдээ санхүүгийн хувьд дэмжих институцийн тогтолцоотой. “Австралийн Зөвлөлийн тухай хууль” (Australia Council Act)-ийг 1975 онд батлан “Үндэсний урлагийн зөвлөл”-ийг байгуулсан. Тус зөвлөлийг 2023 оны хуулийн шинэчилсэн найруулгаар “Бүтээлч Австрали” болгон өөрчилсөн бөгөөд холбооны төсвөөс урлагийн бүхий л төрөлд (уран зураг, тайз, хөгжим, утга зохиол гэх мэт) санхүүжилт олгодог. “Бүтээлч Австрали” урлагийн зөвлөл нь дүрслэх урлагийн төслүүд, үзэсгэлэн, уран бүтээлчийн сургалт, орон нутгийн урлагийг хөгжүүлэх хөтөлбөрүүд зэрэгт зээл, буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалт, тэтгэлэг олгох хэлбэрээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлдэг байна.

АНУ “Урлаг, хүмүүнлэгийн үндэсний сангийн тухай хууль”[11]-ийг 1965 онд батлан, энэ хуулийн хүрээнд холбооны төсвөөс санхүүждэг “Үндэсний урлагийн сан” болон “Үндэсний хүмүүнлэгийн сан”-г байгуулсан байна. Эдгээр нь үндэсний хэмжээнд урлагийн төсөл, уран бүтээлчдэд санхүүгийн тусламж үзүүлэх эрх бүхий бие даасан агентлагууд юм. “Үндэсний урлагийн сан” дүрслэх урлагийн үзэсгэлэн, судалгаа, уран бүтээлчдэд зориулсан хөтөлбөрүүд, орон нутгийн соёлын санаачилгууд зэрэг өргөн хүрээний санхүүгийн дэмжлэгийг уран бүтээлчдэд олгодог байна. “Үндэсний Урлагийн Зөвлөл” тус санг удирддаг.

Мөн АНУ-ын олон хотуудад “Percent for Art” хөтөлбөр хэрэгжиж хот, мужийн удирдлагууд шинээр, нийтийн зориулалттай барилга барих төсвийнхөө 1%-ийг урлагийн бүтээл (уран баримал, зураг г.м) санхүүжүүлэхэд зориулах журам тогтоосон байна (National Assembly of State Arts and

[9] Австрали, Resale Royalty Right for Visual Artists Act 2009. Хандах: https://www.legislation.gov.au/C2009A00125/latest/text
[10] Герман, Law on Copyright and Related Rights. Хандах: https://www.gesetze-im-internet.de/urhg/__26.html?utm_source .
[11] АНУ, 20 U.S. Code Chapter 26 Subchapter 1-National Foundation on the Arts and the Humanities. Хандах: https://www.law.cornell.edu/uscode/text/20/chapter-26/subchapter-I .

Agencies, n.d.). Энэ нь дүрслэх урлагийн бүтээлийг нийтийн орон зайд байршуулах, уран бүтээлчдэд бүтээлээ зах зээлийн эргэлтэд оруулах боломжийг гаргаж өгөх бодлогын зохицуулалт болжээ. Тухайлбал, Сиэтл хот 1973 онд анх 1%-ийн дүрмийг баталж, олон тооны барилга байгууламжийн дэргэд, эсвэл дотор нь байрлах урлагийн бүтээлийг санхүүжүүлсэн байна.

Герман Улс нь "Уран бүтээлчдийн нийгмийн даатгалын тухай хууль"[12]-ийг 1981 онд баталж, чөлөөт уран бүтээлч, сэтгүүлчдийг нийгмийн даатгалд (тэтгэвэр, эрүүл мэнд, асаргааны даатгал) хамрагдах боломжийг бүрдүүлжээ. Уг тогтолцооны дагуу чөлөөт уран бүтээлч нь даатгалын шимтгэлийн тал хувийг өөрөө төлөх ба үлдсэн тал хувийг холбооны төсвөөс татаас олгох болон уран бүтээлчдийн хамтран ажиллаж буй байгууллагуудаас (хэвлэлийн газар, галерей, телевиз, радио зэрэг) гаргуулахаар зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, захиалгаар ажил гүйцэтгүүлж буй аж ахуйн нэгжүүд нь тухайн уран бүтээлчид төлсөн хөлсний тодорхой хувийг нийгмийн даатгалын шимтгэл болгон улсад тушааж, нийгмийн даатгалын санд төвлөрүүлдэг. Ингэснээр чөлөөт уран бүтээлч эрүүл мэнд, тэтгэврийн даатгалд хамрагдах, ирээдүйдээ хуримтлал үүсгэх нөхцөл бүрдэж, уран бүтээлчийн нийгмийн баталгаа хангагдахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Өмнөд Солонгос Улс уран бүтээлчдийнхээ хөдөлмөр эрхлэлтийн баталгаа, нийгмийн хамгааллыг дээшлүүлэх зорилгоор "Уран бүтээлчийн нийгмийн хамгааллын тухай хууль"[13]-ийг 2011 онд баталсан байна. Энэ хууль нь уран бүтээлчийн мэргэжлийн статустай холбоотой эрхийг хуульчлан (§3), төр, орон нутгийн захиргаа нь уран бүтээлчдийн эрхийг хамгаалах, тэдний нийгмийн халамжийг сайжруулах бодлого хэрэгжүүлэх үүрэгтэй болохыг заажээ (§4). Хуулийн хүрээнд "Уран бүтээлчдийн халамжийн сан"-г байгуулсан (§8) бөгөөд тус сангаар дамжуулан уран бүтээлчдэд эрүүл мэндийн даатгалд дэмжлэг үзүүлэх, тэтгэмж олгох, бүтээл туурвих хугацаанд хөдөлмөрийн харилцаа завсардвал орлогын дэмжлэг үзүүлэх зэрэг олон төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Түүнчлэн тус хуулиар 5 жил тутам "Уран бүтээлчдийн нийгмийн хамгааллын үндэсний мастер төлөвлөгөө"-г боловсруулж, хэрэгжүүлж байхыг Соёлын сайдад даалгасан байна. Эдгээр зохицуулалт нь уран бүтээлчдийн ажил хөдөлмөрийн өвөрмөц онцлогт тохирсон нийгмийн хамгааллын тогтолцоог бүрдүүлж, уран бүтээлчид ажилгүйдэл, эрүүл мэнд, тэтгэврийн асуудлаар бусад салбарын ажилтнуудтай адил төрийн дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тус хууль батлагдсанаар уран бүтээлчдийн эрх зүйн хамгаалалт өсч, гэрээний маргаан, шударга бус хөдөлмөрийн нөхцөлөөс хамгаалагдах эрх зүйн үндэс бүрджээ.

Япон Улсын Засгийн газраас 1990 онд урлаг, соёлын хөтөлбөрүүдэд санхүүжилт олгох зорилгоор "Японы Урлагийн Зөвлөл", тус зөвлөлөөр удирдуулсан "Японы урлагийн сан"-г байгуулж, уламжлалт болон орчин үеийн урлагийг дэмжих санхүүжилтийг эхлүүлсэн байна. Тус сан нь театр, хөгжим, дүрслэх урлагийн төслүүдийг санхүүжүүлэх, уран бүтээлчдэд тэтгэлэг, шагнал олгох, үндэсний театр, музейн үйл ажиллагааг дэмжих зэрэг үүрэгтэй ажилладаг. 2003 онд "Японы Урлагийн Зөвлөл – хараат бус захиргааны байгууллага"-ын тухай хуулийг баталсан байна.

[12] Герман, Law on Social Insurance for self-employed artists and journalists. Хандах: https://www.gesetze-im-internet.de/ksvg/?utm_source .
[13] Өмнөд Солонгос, Artist Welfare Act, 2011. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=48734&key=38&type=part&utm_source .

Татварын хөнгөлөлт, урамшууллын дэмжлэг

Судалгаанд авсан улс орнуудад соёл, урлагийн бүтээлийг ивээн тэтгэх, хандивлах үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжиж байна. Мөнгөн болон эд зүйлийн хандив өгсөн хувь хүн, эсхүл корпорацын орлогын албан татварыг тодорхой хувиар суутгах (Австрали, АНУ, Герман, Япон), суутгалыг 1-5 хүртэл жилийн хугацаанд хуваан суутган тооцох зэрэг зохицуулалт хэрэгжүүлж байна (Австрали, АНУ, Герман, Япон). Харин Өмнөд Солонгос Улсын хувьд хувь хүний хандивыг татварын кредит, хуулийн этгээдийн хандивыг зардалд тооцох хэлбэрээр 10 жилийн хугацаанд суутган тооцохоор тус тус зохицуулжээ.

Ийнхүү хандивыг зохистой үнэлж татварын хөнгөлөлт үзүүлснээр нэг талаар музей, номын сан зэрэг улсын сан хөмрөг хувийн цуглуулгаас үнэ цэнтэй бүтээлийг татан авах боломж бүрддэг бол нөгөө талаар хандивлагчид орлогын татвараасаа хөнгөлөлт эдлэх боломж эдэлдэг байна.

Тодруулбал, **Японд** “Корпорацын татварын тухай хууль”[14]-д заасны дагуу “тодорхой нийтэд үйлчилдэг байгууллага”-д өгсөн болон Сангийн сайдын “тусгайлан заасан хандив”-т хамаарах соёлын зорилтот хандивыг ердийн хандиваас давуу горимоор, зарим тохиолдолд бүрэн дүнгээр зардалд тооцон суутгахаар заажээ (§37). Энэ нь компаниудын урлагийг дэмжих сан байгуулах, соёл-урлагийн төслүүдийг урт хугацаанд, тогтмол санхүүжүүлэх сонирхлыг бодитоор нэмэгдүүлдэг байна. Хувь хүмүүсийн хувьд “Орлогын албан татварын тухай хууль”[15]-ийн 78-р зүйлээр хандив өгсөн тохиолдолд тооцох суутгалыг зохицуулсан байна.

Австрали Улсад уран бүтээлчдийг дэмжих, тэдний эрхийг хамгаалах олон төрлийн үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаагийн дотор “Орлогын татварын үнэлгээний тухай хууль”[16]-д заасны дагуу (§30) “Урлагийн бүтээл бэлэглэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна (Office for the Arts , n.d.). Хуулиар нийтийн цуглуулгад урлагийн бүтээл болон мөнгөн хандив хандивлагч нь орлогын татвараас хандивын өгсөн дүнтэй тэнцүү хэмжээгээр суутгуулах боломж (§30-15), суутгалыг татвар төлөгчийн сонголтоор 1-5 орлогын жилд хуваан суутган тооцох эрх (§30-DB), урлагийн бүтээл хүлээн авагчид тавигдах шалгуур (§30-100) зэргийг зохицуулсан байна.

АНУ-д Татварын хуулийн хүрээнд[17] нийтэд үйлчилдэг байгууллагад (үүнд, 26 U.S.C. §501(c)(3)-ын хүрээний музей, галерей гэх мэт) өгсөн мөнгөн хөрөнгө, эсхүл урлагийн бүтээлд хандивын суутгал ногдуулахаар зохицуулжээ (26 U.S.C. §170). Бүтээлийн үнийн хэт үнэлгээтэй холбоотой маргаан гардаг тул АНУ-ын Дотоод орлогын алба (IRS) “Урлагийн үнэлгээний хороо”-г байгуулан 5000 ам.доллараас дээш үнэлгээтэй хандивласан урлагийн бүтээлийн үнэ цэнийг давхар нягталж үнэлгээ өгдөг журамтай байна (Internal Revenue Services, n.d.).

Герман Улсад “Орлогын албан татварын тухай хууль”[18]-ийн (§10b) болон “Корпорацын (хуулийн этгээдийн) орлогын албан татварын тухай хууль”[19]-ийн (§9)-д зааснаар нийтэд тустай зорилгыг дэмжих хувь хүн болон аж ахуйн нэгжийн мөнгөн болон эд хөрөнгийн (үүнд урлагийн бүтээлийг мөн багтаана) хандиваас нийт орлогын 20% хүртэл (бизнесийн хувьд нийт

[14] Япон, Corporation Tax Act. Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3115?utm_source .
[15] Япон, Income Tax Act. Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3120?utm_source= .
[16] Австрали, Income Tax Assessment Act 1997. Хандах: https://www.ato.gov.au/law/view/document?docid=PAC/19970038/30-1 .
[17] АНУ, Internal Revenue Code, 26 U.S.C. §170. Хандах:
[18] Герман, Income Tax Act. Хандах: https://ra.de/g/estg-10b?utm_source .
[19] Герман, Corporate Tax Act. Хандах: https://www.gesetze-im-internet.de/kstg_1977/inhalts_bersicht.html?utm_source .

борлуулалтын орлого болон олгосон цалин, хөлсний нийлбэрийн 0.4%-ийг) суутгалд хамруулахаар зохицуулжээ. Хэтэрсэн дүнг дараагийн жилүүдэд шилжүүлэн суутгах боломжтой байна.

Өмнөд Солонгос Улсад соёл урлагийг дэмжих зорилтот хандивыг “Орлогын албан татварын тухай хууль”[20] болон “Корпорацын орлогын албан татварын тухай хууль”[21]-аар тус тус зохицуулж байна. Ингэхдээ нийтэд үйлчилдэг байгууллагад (соёл урлагийн байгууллага) өгсөн мөнгөн болон эд хөрөнгийн хандивыг хувь хүний хувьд татварын кредит (§59-4), хуулийн этгээдийн хувьд зардалд хасалт хэлбэрээр (§24) урамшуулахаар зохицуулжээ. Хандивын урамшууллыг иргэн болон хуулийн этгээд аль алинд нь 10 жилийн хугацаанд тооцох боломжтой байна.

[20] Өмнөд Солонгос, Income Tax Act, 2011. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/ganadaDetail.do?hseq=51753&key=INCOME+TAX+ACT&param=I&type=abc
[21] Өмнөд Солонгос, Corporate Tax Act 1998, Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=63450&key=20&type=part

ХОЁР. УРЛАГИЙН БҮТЭЭЛИЙГ СОЁЛЫН ӨВД БҮРТГЭХ, УЛСЫН БОЛОН НИЙТИЙН САН ХӨМРӨГТ ХУДАЛДАН АВАХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ

Судалгаанд авсан орнуудад өндөр ач холбогдолтой, үнэ цэнтэй хөдлөх соёлын өвийг (биет урлагийн бүтээл, цуглуулга, дурсгалын зүйлс зэрэг) тусгай ангиллаар бүртгэх, экспорт/импортын хяналт тогтоох, улсын болон нийтийн сан хөмрөгт худалдан авдаг санхүүжилтийн механизмтай байна. Австрали, Герман, Япон улсад экспортын хяналтын тодорхой бүртгэлтэй, тусгай зөвшөөрлийн горимтой бол АНУ-д импортын хязгаарлалтаар олон улсын соёлын өмчийг хамгаалах зохицуулалттай байна. Өмнөд Солонгос Улсын хувьд “Соёлын өвийн хамгааллын тухай хууль”-аар дээрх бүх харилцааг зохицуулж байна.

Урлагийн бүтээлийг соёлын өвд бүртгэх

Судалгаанд авсан орнуудад урлагийн бүтээлийг соёлын өвд бүртгэх асуудлыг соёлын өвийг хамгаалах тухай хуулиар зохицуулж байна (Герман (§7)[22], Өмнөд Солонгос (§53)[23], Япон (§27-29)[24]). АНУ-д урлагийн бүтээлийг тодорхой орчин, байршилтай салшгүй холбоотой объект ангиллаар “Түүхэн дурсгалт газрын Үндэсний бүртгэл”-д бүртгэдэг (§60.3, 60.4).[25] Харин Австрали Улсын хувьд соёлын хөдлөх биет өвд үндэсний хэмжээний нэгдсэн бүртгэл байхгүй, мужийн хууль (тухайлбал, Өмнөд Австрали мужийн Соёлын өвийн тухай хууль[26])-аар бүртгэн, хамгаалалтад авдаг байна.

Урлагийн бүтээлийг соёлын өвд бүртгэхдээ тодорхой шалгуурын үндсэн дээр, мэргэжлийн үнэлгээнд суурилдаг бөгөөд дараах нийтлэг шалгуурыг тавьдаг байна. Үүнд:

- Түүх-соёлын ач холбогдолтой байх;
- Бүрэн бүтэн, жинхэнэ эх хувь байх;
- Ховор, онцгой, үнэт шинж чанартай байх;
- Гарал, үүсэл тодорхой байх;
- Түүх, урлаг судлалд шинэ мэдлэг, мэдээлэл өгөх магадлалтай баримт мэдээлэл агуулсан байх;
- Олон нийтийн соёлын ашиг сонирхол, үндэсний болон орон нутгийн түвшинд ач холбогдолтой байх зэрэг болно.

Улсын болон нийтийн сан хөмрөгт урлагийн бүтээл худалдан авах, хадгалах, хамгаалах

Судалгаанд хамрагдсан орнуудад улсын болон нийтийн сан хөмрөгт урлагийн бүтээл худалдан авах болон хадгалах, хамгаалах суурь чиг үүргийг нийтлэгээр институцийн түвшний буюу үндэсний музей, галерейн хуулиар зохицуулж байна (Австрали, АНУ, Өмнөд Солонгос, Япон). Герман Улсад холбооны музей, галерей нь тус тусын хуулиар энэ чиг үүргийг хэрэгжүүлж

[22] Герман, Cultural Property Protection Act. Хандах: https://ra.de/g/kgsg-6
[23] Өмнөд Солонгос, Cultural Heritage Protection Act. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawViewContent.do?hseq=26478
[24] Япон, Law for the Protection of Cultural Properties. Хандах: https://www.wipo.int/wipolex/en/legislation/details/6935
[25] АНУ, 36 CFR Part 60. National Register of Historic Places. https://www.ecfr.gov/current/title-36/chapter-I/part-60?utm_source
[26] Австрали, NSW Heritage Act 1977. Хандах: https://legislation.nsw.gov.au/view/whole/html/inforce/current/act-1977-136?utm_source

байна. Харин тус улсад “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”[27]-аар соёлын үнэт зүйлсийг гэмтээхийг эрс хориглож (§18), алдагдах, болон ямар нэг өөрчлөлт илэрмэгц шуурхай мэдээлэх үүргийг (§19) хуульчилсан байна. Өмнөд Солонгос (§23, 53)[28] болон Япон улсад (§43)[29] урлагийн бүтээлийн бүртгэл ба ангилал нь тодорхой шатлалтай тул хамгаалалтын хүч, цар хүрээ нь ангиллаасаа шалтгаалан өөр түвшинд хэрэгждэг байна.

Судалгаанд авсан орнуудад урлагийн бүтээл худалдан авах ажиллагаа нь төрийн худалдан авах ерөнхий дүрэм, журмын хүрээнд явагдах бөгөөд зарим тохиолдолд урлагийн бүтээлийн цор ганц, орлуулшгүй шинжийг харгалзан өрсөлдөөнгүй шууд худалдан авах онцгой горимыг ашигладаг байна.

Худалдан авалтын санхүүжилтийг холимог эх үүсвэрээс бүрдүүлж байна. Үүнд, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт улс болгонд нийтлэгээр байгаа бөгөөд үүн дээр тусгай сан, хөтөлбөр, хандив, итгэлцлийн сан зэрэг эх үүсвэрүүд нэмэгдэнэ. Эдгээр нь улс орнуудад харилцан адилгүй байдлаар хэрэгжинэ. Тухайлбал, **АНУ-д** “Үндэсний урлагийн галерейн тухай хууль”-д зааснаар төсвийн хөрөнгийг урлагийн бүтээл худалдан авах зардалд бус үйл ажиллагаа, хамгаалалтын зардалд зарцуулдаг. Тус улсад хувийн сан, хандив, итгэлцлийн сангийн санхүүжилтээр, төр-хувийн түншлэлээр өндөр үнэлгээтэй бүтээлийг улсын сан хөмрөгт худалдан авдаг байна.

Хүснэгт 2. Урлагийн бүтээл худалдан авах эрх зүйн зохицуулалт, санхүүжилт

Улс	Хууль, тогтоомж	Санхүүжилтийн эх үүсвэр
Австрали	“Үндэсний галерейн тухай хууль” (§s6, 7)	- Улсын төсөв[30] - Үндэсний галерейн сангийн хөрөнгө (хандив) (Australian Gov Transparency Portal, 2023) - Үндэсний соёлын өвийн тусгай сангийн худалдан авах зардлын дэмжлэг [31]
АНУ	“Үндэсний урлагийн галерейн тухай хууль” (§71-75)[32]	- Холбооны төсөв – үйл ажиллагаа, хамгаалалтын зардал (§74) - Хувийн сан, хандив, итгэлцлийн сан (Trust fund) (§74b, 75)
Герман	“Соёлын өвийг хамгаалах тухай хууль” ЕХ-ны 2014/24/EU удирдамж (§32)	- Холбооны болон мужийн төсөв, - Татаас (Federal Art Purchase commission , n.d.) - Хандив (татварын урамшуулалтай)

[27] Герман, Cultural Property Protection Act. Хандах: https://www.gesetze-im internet.de/kgsg/__23.html?utm_source
[28] Өмнөд Солонгос, Cultural Heritage Protection Act. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawViewContent.do?hseq=26478
[29] Япон, Law for the Protection of Cultural Properties. Хандах:https://www.wipo.int/wipolex/en/legislation/details/6935
[30] Австрали, Public Governance, Performance and Accountability Act 2013. Хандах: https://www.finance.gov.au/government/managing-commonwealth-resources/pgpa-legislation-associated-instruments-and-policies?utm_source .
[31] Австрали, National Cultural Heritage Account. Хандах: https://www.grants.gov.au/Go/Show?GoUuid=ad48b45d-a2e6-4b7d-a934-c4b056abe184&utm_source .
[32] АНУ, 20 U.S. Code Chapt 3 Subchapt II-National Gallery of Art. Хандах: https://www.law.cornell.edu/uscode/text/20/chapter-3/subchapter-II?utm_source

	“Нийтийн худалдан авах ажиллагааны журам” (§14(4) № 2 (a))	
Өмнөд Солонгос	“Музей, урлагийн галерейг дэмжих тухай хууль” (§4.(1), 8) “Төрийн оролцоотой гэрээний тухай хууль” (§7) “Соёл, урлагийг дэмжих тухай хууль”[33] - Соёл, урлагийг дэмжих сан (§7)	- Улсын төсөв (§2) - Татаас (§10, 24) - Хандив (татварын урамшуулалтай)[34] - Сангийн орлого
Япон	“Музейн тухай хууль”[35] Бие даасан захиргааны байгууллага – “Үндэсний урлагийн музейн тухай хууль” (§3, 11 (2))[36]	- Улсын болон орон нутгийн төсөв - Татаас - Музейн өөрийн орлого - Хандив (татварын урамшуулалтай)

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Австрали Улсын Үндэсний галерей нь бие даасан хуультай бөгөөд улсын сан хөмрөгт урлагийн бүтээл худалдан авах үйл ажиллагааг дотооддоо баталсан дүрэм, худалдан авалтын бодлогын дагуу хийдэг.[37] Тухайлбал, “Үндэсний галерейн тухай хууль”[38]-д галерей нь үндэсний хэмжээнд үнэ цэнтэй урлагийн бүтээлийн цуглуулгыг бүрдүүлэх, тэдгээрийг худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хуульчилсан байна. Тус хуулийн дагуу галерейн зөвлөл нь өндөр өртөг бүхий бүтээл худалдан авах шийдвэр гаргахын өмнө тухайн бүтээлийн мэргэжлийн үнэлгээг хийлгэхийг шаарддаг нь улсын сан хөмрөгт худалдан авах ажиллагааг зах зээлийн үнэлэмжид нийцүүлэн, ил тод явуулах баталгааг бий болгожээ. “Соёлын хөдлөх биет өвийг хамгаалах тухай хууль”[39]-аар “Үндэсний урлагийн өвийн тусгай данс” (§25)-ыг бий болгон олон нийтийн цуглуулгад авч үлдэх өндөр ач холбогдолтой объектын худалдан авалтыг санхүүжүүлэхэд зарцуулахаар заажээ.

Мөн “Зээлээр авчирсан соёлын биет зүйлсийг хамгаалах тухай хууль”[40]-аар бусад улс орноос үзэсгэлэнд түр ирсэн бүтээлийг шүүхийн маргаан, хураалт, битүүмжлэлийн арга хэмжээ зэргээс 24 хүртэлх сарын хугацаанд хамгаалдаг байна.

Герман Улсын уран зургийн галерей, музей нь ихэвчлэн төрийн мэдэлд, төрийн санхүүжилттэй байдаг бөгөөд тэдгээр нь соёлын яам, урлагийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр шинэ бүтээл худалдан авах, цуглуулгаа баяжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Ингэхдээ Европын Холбооноос баталсан удирдамжийг баримтлан холбооны болон мужийн хамтарсан санхүүжилтээр үндэсний ач холбогдолтой, олон нийтийн цуглуулгад үлдээх шаардлагатай цор

[33] Өмнөд Солонгос, Culture and Arts Promotion Act. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=2714&key=17&type=part&utm_source
[34] Өмнөд Солонгос, Act on Collection and Use of Donations. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=47137&key=15&type=sogan&utm_source
[35] Япон, Museum Act. Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4309/en?utm_source
[36] Япон, Independent Administrative Institution National Museum Law. Хандах: https://hourei.net/law/411AC0000000177
[37] Австрали, Commonwealth Procurement Rules. Хандах: https://www.legislation.gov.au/F2024L00627/asmade/text
[38] Австрали, National Gallery Act 1975. Хандах: https://nga.gov.au/media/dd/documents/nga_act1975.pdf
[39] Австрали, Protection of Movable Cultural Heritage Act. Хандах: https://www.legislation.gov.au/C2004A03252/2024-10-14/2024-10-14/text/original/epub/OEBPS/document_1/document_1.html
[40] Австрали, Protection of Cultural Objects on Loan Act 2013. Хандах: https://www.legislation.gov.au/C2013A00012/2024-10-14/2024-10-14/text/original/epub/OEBPS/document_1/document_1.html

ганц бүтээлийг хамтран худалдан авах зэргээр улсын сан хөмрөгийг баяжуулдаг. Тус улсын Засгийн газар 2016 онд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг баталснаар үндэсний ач холбогдолтой бүтээлийг хувийн цуглуулгаас худалдан авч музейд шилжүүлэхэд зориулан хөрөнгө гаргах механизмыг бүрдүүлсэн байна (§ 23(6))[41]. Ингэснээр зах зээл дээр гарах онцгой бүтээлийг улсын хөрөнгөөр худалдан авч, олон нийтийн өмч болгон хамгаалах нөхцөл бүрджээ.

Холбооны Засгийн газрын санхүүжилттэй “Соёл, урлагийн сан” (Federal Cultural Foundation, n.d.) нь томоохон үзэсгэлэн, төслийг санхүүжүүлэх, бүтээл худалдан авахад татаас өгдөг. Холбооны Урлагийн Захиргааны харьяа Орчин үеийн урлагийн цуглуулга нь бие даасан мэргэжлийн комиссоороо дамжуулан жил бүр тогтоосон төсвийн хүрээнд урлагийн бүтээл худалдан авч, бүтээлүүдийг яамд, элчин сайдын яамд болон музейд урт/богино хугацаагаар зээлээр байршуулдаг байна (Bundeskunstsammlung, n.d.).

Өмнөд Солонгос Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”[42] нь түүх, соёлын хосгүй үнэт эд өлгийн зүйлсийг улсын хамгаалалтад авч, “Үндэсний соёлын өв” ангилалд оруулж зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргахыг хориглох, эвдэрч, гэмтэхээс хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалттай байна. Энэ хуулиар Өмнөд Солонгосын уламжлалт уран зураг, эртний дурсгалт баримал зэрэг нь “Үндэсний хосгүй үнэт” эсхүл “Түүхийн дурсгалт” зэргээр ангилагдсан бол хуулбар хийх, байршлыг солих, гадагш гаргах бүх үйлдэлд холбогдох байгууллагаас зөвшөөрөл авдаг байна.

“Соёл, урлагийг дэмжих тухай хууль”[43]-аар улсын өмчийн урлагийн цуглуулгыг нэгтгэн удирдах, хамгаалах зохицуулалтуудыг хийжээ (§23). Хуульд зааснаар Соёлын яам “Төрийн өмчийн урлагийн бүтээлийн менежментийн мэргэжлийн байгууллага” ба “Нийтийн урлагийн банк”-ийг байгуулан (§30) төрийн байгууллагуудын эзэмшлийн урлагийн бүтээлийг худалдан авч, түрээслэн зээлдүүлж олон нийтэд үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэн, бүтээлүүдийн талаарх нэгдсэн мэдээлэлтэй болж, давхардуулан худалдан авах, эсвэл алдагдах эрсдэлээс сэргийлэх боломж бүрдсэн байна.

Япон Улс 1950 онд “Соёлын өмчийг хамгаалах тухай хууль”-ийг батлан түүхэн урлагийн өв, дурсгалт зүйлсийг улсын хамгаалалтад авах үндсэн механизмыг бүрдүүлсэн. Тус хуулиар Япон Улсын Засгийн газар урлаг, түүх, археологийн үнэт зүйлсийг “Соёлын чухал өв” (§27 (1)) болон “Үндэсний хосгүй үнэт” (§27 (2)) гэх ангиллаар бүртгэн зарлаж, тэдгээр бүтээлийг зөвшөөрөлгүй гадаадад гаргах, устгах, гэмтээхээс хамгаалах үүрэг хүлээдэг. Хувийн эзэмшлийн чухал соёлын үнэт зүйлсийг эзэмшигчийн санал, зөвшилцлөөр улсын өмчид авч болно (§46). Бүтээлийг хамгаалах үүрэг эзэмшигчид ногдож, жил бүр үзлэгт оруулах, гэмтэл гарвал Соёлын агентлагт даруй мэдэгдэх журамтай байна (§33). Тус хуулиар дүрслэх урлагийн бүтээл (уран зураг, гар бичмэл, баримал), түүхэн уран барилгын хэсэг, ардын урлагийн бүтээлүүдийг “Биет соёлын өмч” ангилалд багтаан хамгаалдаг байна (§2 (1) (i)). Энэ хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Япон Улс Соёлын өвийн агентлаг (Agency for Cultural Affairs)-ийг байгуулан, муж бүрд Соёлын өмчийг хамгаалах зөвлөлүүд ажиллаж байна (§190). Тэдгээр нь соёлын чухал өвийг

[41] Герман, Cultural Property Protection Act. Хандах: https://www.gesetze-im-internet.de/kgsg/__23.html?utm_source
[42] Өмнөд Солонгос, Cultural Heritage Protection Act. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawViewContent.do?hseq=26478
[43] Өмнөд Солонгос, Culture and Arts Promotion Act. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=2714&key=17&type=part&utm_source

таниулах үзэсгэлэн, танилцуулга гаргах, хамгаалалтын зааварчилгаа өгөх зэрэг ажлыг гүйцэтгэдэг байна.

Экспорт/ импортын хяналт

Улс орнууд “Соёлын үнэт зүйлийг хууль бусаар импортлох, экспортлох, шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх тухай” ЮНЕСКО-ийн конвенц (1970)[44]-ыг үндэс болгон соёлын өвийн экспорт, импортын хяналтын тогтолцоог хэрэгжүүлж байна. Австрали Улсад “Үндэсний соёлын өвийн экспортын хяналтын жагсаалт”-ыг батлан урлагийн бүтээлийг А (экспортын хоригтой), Б (зөвшөөрөлтэй экспортлох) гэж ангилдаг бөгөөд Б ангиллын бүтээлд 30 жилийн нас бүхий (§ 5.2(b)), тодорхой үнэлгээний босго давсан (§ 5.4) байх шаардлага тавигддаг.[45] Харин АНУ-д урлагийн бүтээлийн импортын хяналт давамгай[46] бөгөөд импортод хоёр талт хэлэлцээрээр тогтоогдсон урлагийн бүтээлийн “Соёлын өвд тооцсон жагсаалт”-ыг баримталдаг.[47] Герман Улсын хувьд урлагийн бүтээлийг Европын Холбооноос гадагш буюу гуравдагч орон руу гаргахдаа “Европын зөвлөлийн журам 116/2009”[48], харин Европын Холбооны улс руу экспортлоход үндэсний “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-д зааснаар 50 жил хүрсэн, тодорхой үнэлгээний босго болон бусад шалгуурыг хангасан бүтээлийг (§22-24)[49] лицензжүүлэхийг шаарддаг байна. Япон Улс нь 2002 онд “Соёлын өвийн хууль бус экспорт, импортын хяналтын тухай”[50] бие даасан хуулийг батлан мөрдөж байна.

[44] UNESCO Convention 1970. Хандах: https://www.unesco.org/en/legal-affairs/convention-means-prohibiting-and-preventing-illicit-import-export-and-transfer-ownership-cultural?utm_source
[45] Австрали, National Cultural Heritage Control List. Хандах: https://classic.austlii.edu.au/au/legis/cth/num_reg/pomchr2018201801710518/sch1.html
[46] АНУ, Convention on Cultural Property Implementation Act. Хандах: https://www.law.cornell.edu/uscode/text/19/2601
[47] АНУ, 19 CFR §12.104g. Хандах: https://www.ecfr.gov/current/title-19/chapter-I/part-12/subject-group-ECFRe39e9fce2462969/section-12.104g?utm_source
[48] Герман, CR on the export of cultural goods. Хандах: https://eur-lex.europa.eu/eli/reg/2009/116/oj/eng?utm_source
[49] Герман, Act on the Protection of Cultural Property. Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_kgsg/englisch_kgsg.html .
[50] Япон, Act on Controls on the Illicit Export and Import of Cultural Property 2002. Хандах: https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3791/en

ГУРАВ. ДҮРСЛЭХ УРЛАГИЙН БҮТЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

Судалгаанд хамруулсан улс орнууд дүрслэх урлагийн бүтээлтэй холбоотой гэмт хэргийг соёлын өвийг хамгаалах тухай хууль, эрүүгийн хууль, зохиогчийн эрхийг хамгаалах хуулиар зохицуулж байна.

Судалгаанд хамрагдсан бүх улс орнууд дүрслэх урлагийн салбартай холбогдох гэмт хэрэгтэй тэмцэхдээ энэ талаар тусгайлан мэргэшсэн нэгж болон тусгай механизмыг бүрдүүлсэн байна. Тухайлбал, АНУ-ын Холбооны мөрдөх товчооны Урлагийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгж, Өмнөд Солонгосын Соёлын өвийн цагдаа, Японы соёлын өв, урлагийн бүтээлийн хулгайтай тэмцэх мэргэшсэн алба зэрэг болно. Соёлын үнэт өвийн хууль бус экспорт, импорт, худалдааг таслан зогсоох чиглэлээр хил гааль, цагдаагийн байгууллагууд дотооддоо хамтран ажиллахын зэрэгцээ олон улсын түвшинд бусад улс орнуудтай хамтран ажилладаг.

Мөн АНУ-ын Холбооны мөрдөх товчооны “Үндэсний хулгайлагдсан урлагийн бүтээл” (FBI, n.d.) онлайн мэдээллийн сан, Германы урлагийн бүтээлийн гарал үүслийг тодорхойлох үүрэг, Өмнөд Солонгосын урлагийн зуучлагчдын бүртгэл, гэрчилгээжүүлэлт, бүтээлийн баталгааны гэрчилгээ зэрэг нь энэ салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд чухал алхмууд болсон байна.

Соёлын өвийн хууль зөрчих, урлагийн бүтээл хулгайлах, санаатайгаар эвдэх, сүйтгэх зэрэгт эрүүгийн хуулиар хариуцлага ногдуулдаг (АНУ, Австрали, Япон 10 хүртэл жил, Герман 5 хүртэл жил). Өмнөд Солонгос Улсын хувьд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-д зааснаар 3-5 хүртэл жилээр хорих ялаар шийтгэж байна (§92).

Австрали Улсад “Үндэсний дүрслэх урлагийн холбоо”-оос “Дүрслэх урлаг, гар урлал, дизайны салбарын ёс зүйн дүрэм”-ийг боловсруулан мөрдөж байна (National Association for the Visual Arts, 2022). Энэхүү дүрэмд галерей, дилер, цуглуулагчид уран бүтээлчтэй шударга гэрээ байгуулах, зохиогчийн эрхийг чанд мөрдөх, бүтээлийг зохих нөхцөлд хадгалах зэрэг сайн туршлагуудыг тусгасан бөгөөд салбарынхан сайн дураар даган мөрдөх замаар зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулдаг байна.

АНУ урлагийн бүтээл, соёлын үнэт өвийн хууль бус худалдаа, хулгайн эсрэг олон улсын түвшинд идэвхтэй арга хэмжээ авдаг. 1983 онд АНУ-ын Конгрессоор “Соёлын өвийн конвенцыг хэрэгжүүлэх тухай хууль”-ийг баталж гадаад орнуудаас хууль бусаар түүхийн олдвор, урлагийн бүтээл импортлоход хориг тавих механизмыг бүрдүүлжээ. Энэ хуулийн дагуу АНУ нь олон улс оронтой хоёр талын соёлын өвийг хамгаалах гэрээ байгуулж, тодорхой цаг хугацааны өмнө бий болсон археологийн болон урлагийн эд зүйлийг тухайн улсаас зөвшөөрөлгүй оруулж ирвэл хураан, буцаах эрхтэй болсон байна.

Мөн “Үндэсний урлагийн бүтээл хулгайлах гэмт хэрэг”-ийн заалтыг 1994 онд Эрүүгийн хуульдаа нэмж, музей, номын сангаас үнэт урлагийн бүтээл хулгайлсан тохиолдолд холбооны хэмжээнд хүнд гэмт хэрэгт тооцохоор зохицуулжээ (§668).[51]

[51] АНУ, 18 U.S.C.668. Theft of Major Artwork. Хандах: https://www.law.cornell.edu/uscode/text/18/668

Герман Улсад “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”[52] нь урлагийн салбарын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гол хэрэгсэл болж байна. Тус хуулийн дагуу урлагийн бүтээлийн дилерүүдэд “бүтээлийн гарал үүслийг тодорхойлох үүрэг”-ийг ногдуулсан байна (§42).

Өмнөд Солонгос Улсад 2023 онд “Соёл, урлагийг дэмжих тухай хууль”[53]-ийг баталсан нь урлагийн бүтээлийн хууль бус хувилбар хийх, хуурамч зураг худалдаалах зэрэг зөрчлөөс сэргийлэх томоохон алхам болсон. Хуулийн хүрээнд урлагийн бүтээлийн зуучлагчдыг бүртгэж, гэрчилгээжүүлэх болсон нь зөвхөн эрх бүхий субьект зуучлал хийх нөхцөл бүрдүүлж, хэн хаана ямар бүтээл зуучилж байгааг хянах боломжтой болсон (§18). Мөн энэ хуулийн дагуу галерей, дуудлага худалдааны газрууд нь бүтээл худалдсаны дараа худалдан авагчид баталгааны гэрчилгээ олгох үүрэг хүлээсэн нь тухайн бүтээлийн гарал үүсэл, үнэн бодит байдлыг гэрчлэх баримт болдог байна (16(3)).

Япон Улсад соёлын өвийг хууль бусаар хил давуулах оролдлогыг гаалийн алба дэвшилтэт технологи ашиглан (рентген скан, хиймэл оюуны дүрс танилт г.м) илрүүлэх чадвартай байна. Соёлын үнэт өвийг хууль бусаар хил давуулахыг завдсан тохиолдолд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-д заасны дагуу 5 жил хүртэл хорих ял, эсхүл 1 сая иен хүртэлх торгууль, эсхүл хамтад нь ногдуулахаар заажээ (§106).

[52] Герман, Cultural Property Protection Act. Хандах: https://www.gesetze-im-internet.de/kgsg/__23.html?utm_source

[53] Өмнөд Солонгос, Art Promotion Act 2023. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=68295&key=17&type=part .

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан улсуудын дүрслэх урлагийн салбарын эрх зүйн зохицуулалт харилцан адилгүй загвар, онцлогтой ч нийтлэг нэг зорилгод чиглэдэг нь урлагийн үнэт бүтээл, уран бүтээлчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, улмаар соёлын өвийг үе дамжуулан хадгалах, хамгаалах явдал байдаг.

Судалгаанд авсан Өмнөд Солонгос Улс дүрслэх урлагийн зах зээлээ зохицуулах “Дүрслэх урлагийг дэмжих тухай” бие даасан хуулийг 2023 онд баталсан байна. Энэ хуулиар уран бүтээлч, захиалагч болон галерей хоорондын гурван талын харилцаанд шударга байдлыг хангах, төрийн хяналтыг тодорхой хэмжээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна. Герман болон Япон улсад дүрслэх урлагтай холбоотой харилцааг соёл, оюуны өмчийн ерөнхий хуулиар зохицуулдаг. Харин Австрали Улсад дүрслэх урлагийн зах зээл дэх дахин борлуулалтад чиглэсэн “Дүрслэх урлагийн дахин борлуулалтын эрхийн тухай хууль” тусгайлан үйлчилж байгаа бол, АНУ-д Холбооны зохиогчийн эрхийн хуульд нэмэлт болгон баталсан “Дүрслэх урлагийн уран бүтээлчдийн эрхийн тухай хууль” нь дүрслэх урлагийн бүтээлд хамаарах зохиогчийн эдийн бус (ёс суртахууны) эрхтэй холбоотой асуудлыг тусгайлан зохицуулсан байна. Герман Улсад соёлын өвөө хамгаалах нарийвчилсан зохицуулалтыг холбогдох хуулиудаар хэрэгжүүлдэг бөгөөд уран бүтээлчдээ нийгмийн халамжийн үйлчилгээнд татан оруулсан шилдэг шийдэлтэй байна.

Австрали, Герман, Өмнөд Солонгос, Япон Улсад зохиогчийн нэр хүнд, бүтээлийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах эдийн бус эрхийг зохиогчийн насан туршийн хугацаанд, үүнээс Герман, Японд нас барснаас хойш 70 жилийн хугацаанд үргэлжлэхээр зохицуулсан байна. Харин АНУ-д эдгээр эрх нь зөвхөн дүрслэх урлагийн тодорхой төрөл (тухайлбал, уран зураг, баримал)-д хязгаарлагдсан хүрээнд, ихэвчлэн зохиогч амьд ахуйд хэрэгжихээр хуульчилсан байна.

Судалгаанд авсан орнуудаас Австрали, Герман, Өмнөд Солонгос улсад урлагийн бүтээлийн дахин борлуулалтад зохиогч хувь хүртэх эрхийг хуулиар зохицуулсан байгаа бол АНУ, Япон улсад энэ асуудлыг хуульчлаагүй. Өмнөд Солонгос Улс шинэчилсэн салбарын хуулиар 2027 оноос хэрэгжүүлэхээр тогтоосон, харин АНУ-д “анхны борлуулалтын зарчим”-аар дахин төлбөр ногддоггүй байна.

Бүх улсад соёл урлагийг дэмжих хандивт татварын урамшуулал олгох нийтлэг зохицуулалтын арга хэлбэр бүхий бодлогыг хэрэгжүүлдэг. Австрали, АНУ, Герман, Япон улсад мөнгөн болон эд зүйлийн хандивт орлогын албан татвараас тодорхой хувийг суутгах, зарим тохиолдолд суутгалыг 1–5 жилд хуваан тооцохоор зохицуулсан бол Өмнөд Солонгост хувь хүнд татварын кредит, хуулийн этгээдэд зардалд хасалт хэлбэрээр олгож, аль алинд нь 10 жилийн хугацаанд тооцох боломжтой зохицуулалттай байна. Харин Япон Улсад тодорхой нийтийн ашигт байгууллагад олгосон хандивт давуу горимоор, зарим тохиолдолд бүрэн дүнгээр зардлаас суутгах боломжийг олгосон нь аж ахуйн нэгжийн урт хугацааны ивээн тэтгэлгийг урамшуулах хэрэгсэл болдог байна.

Судалгаанд хамрагдсан орнуудад үнэ цэнтэй соёлын биет өвийг тусгай ангиллаар бүртгэх, хамгаалах, улсын болон нийтийн сан хөмрөгийг баяжуулах зорилгоор худалдан авдаг нийтлэг туршлага байна. АНУ-д Үндэсний урлагийн галерей нь холбооны төсөв болон итгэлцлийн сангаас

санхүүжилт авдаг бол Австралид Үндэсний галерей ба “Үндэсний соёлын өвийн тусгай данс”-д байршсан хөрөнгөөр урлагийн бүтээлийг худалдан авдаг. Герман Улсад холбоо болон мужийн төсвийн хамтарсан эх үүсвэрээр худалдан авалтыг хийдэг бол Өмнөд Солонгост төрийн өмчийн урлагийн цуглуулгын төвлөрсөн менежмент, Японд музейн тухай хууль, бие даасан захиргааны байгууллагын тогтолцоонд тулгуурлан хэрэгжүүлдэг онцлогтой байна.

Урлаг соёлын бүтээлийг хамгаалах тал дээр судалгаанд авсан орнууд бүгд соёлын өвийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ тусгайлан мэргэшсэн байгууллага, нэгжээр дамжуулан урьдчилан сэргийлэх ба мөрдөн шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

АНУ-д Холбооны мөрдөх товчооны “Үндэсний хулгайлагдсан урлагийн бүтээл” мэдээллийн сан, Германд гарал үүслийг нягтлах үүрэг, Өмнөд Солонгост урлагийн бүтээл зуучлагчдын бүртгэл ба бүтээлийн баталгааны гэрчилгээ, Австралид дүрслэх урлагийн салбарын ёс зүйн дүрэм зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаа, арга хэрэгслүүд нь урлагийн бүтээл хулгайд алдагдах, эвдэрч гэмтэх, устаж үгүй болох зэрэг эрсдэлээс сэргийлдэг байна. Урлагийн бүтээлтэй холбоотой гэмт хэрэгт АНУ, Австрали, Японд 10 хүртэл жил, Германд 5 жил, Өмнөд Солонгост соёлын өвийн хуулиар 3–5 жил хүртэл хорих ял оноох болон мөнгөн торгууль ногдуулах зохицуулалттай байна.

ЮНЕСКО-оос 1970 онд баталсан конвенцод үндэслэн урлагийн бүтээлд экспорт, импортын хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд урлагийн бүтээлийн нас болон үнэлгээний босгыг шалгуур болгодог нийтлэг туршлагатай байна. Япон Улсад хууль бус экспорт-импортын бие даасан хуультай бол АНУ-д импортын талын хязгаарлалтыг түлхүү ашигладаг онцлогтой байна.

Судалгаанд хамруулсан улс орнуудад уран бүтээлчийг зах зээлийн шударга бус нөхцөлөөс хамгаалах, орлогын тогтвортой суурь бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаагийн дотор Герман Улсад уран бүтээлчдийн нийгмийн даатгалын тогтолцоо, Өмнөд Солонгост уран бүтээлчийн нийгмийн хамгааллын тухай тусгай хуулиар стандарт гэрээ, халамжийн сангийн тогтолцоог бүрдүүлсэн байна. Австрали, АНУ, Японд үндэсний урлагийн зөвлөл, урлагийг дэмжих сангуудаар дамжуулан буцалтгүй тусламж, тэтгэлэг, хөнгөлөлттэй санхүүжилт олгодог бөгөөд АНУ-ын олон хот “Percent for Art” хөтөлбөрөөр улсын санхүүжилттэй барилга бүрээс урлагт хөрөнгө хуваарилдаг онцлог үйл ажиллагаа хэрэгжүүлдэг зэрэг туршлагууд байна.

WIPO. (n.d.). Summary of the Berne Convention for the Protection of Literary and Artistic Works (1886). From WIPO: https://www.wipo.int/treaties/en/ip/berne/summary_berne.html?utm_source

WIPO. (2016). Understanding Copyright and Related Rights. From WIPO: https://www.wipo.int/edocs/pubdocs/en/wipo_pub_909_2016.pdf

WIPO. (n.d.). WIPO Copyright Treaty. From WIPO: https://www.wipo.int/treaties/en/ip/wct/?utm_source

WIPO. (1996). WIPO Copyright Treaty. From WIPO: https://www.wipo.int/treaties/en/ip/wct/?utm_source

WIPO. (2017). Agreement on Trade-Related Aspects of Intellectual Property Rights (TRIPS Agreement). From WIPO: https://www.wipo.int/wipolex/en/treaties/details/231?utm_source

Lexology . (2019). IP rights in art in Germany. From Lexology : https://www.lexology.com/library/detail.aspx?g=725df9ae-822d-474b-be18-9fbeaf0dcb21#:~:text=What%20are%20the%20moral%20rights,they%20be%20waived%20or%20assigned

U.S. Department of Justice Archives. (n.d.). 1854. Copyright Infringement -- First Sale Doctrine. From U.S. Department of Justice Archives: https://www.justice.gov/archives/jm/criminal-resource-manual-1854-copyright-infringement-first-sale-doctrine

National Assembly of State Arts and Agencies. (n.d.). State Percent for Art Programs. From National Assembly of State Arts and Agencies: https://nasaa-arts.org/nasaa_research/state-percent-art-programs/?utm_source

Office for the Arts . (n.d.). Cultural Gifts Program. From Office for the Arts: https://www.arts.gov.au/funding-and-support/cultural-gifts-program?utm_source

Internal Revenue Services. (n.d.). Art Appraisal Services. From Internal Revenue Services: https://www.irs.gov/appeals/art-appraisal-services#form8283

Australian Gov Transparency Portal. (2023). National Gallery of Australia. From Australian Gov Transparency Portal: https://www.transparency.gov.au/publications/communications-and-the-arts/national-gallery-of-australia/national-gallery-of-australia-annual-report-2022-23/part-3%3A-report-on-performance/foundation?utm_source

Nat Gallery of Art . (n.d.). Supporting the Nat Gallery. From Nat Gallery of Art : https://www.nga.gov/support/frequently-asked-questions-support?utm_source

Federal Art Purchase commission . (n.d.). From the collection's new acquisitions. From Federal Art Purchase commission : https://www.kunstsammlung-bund.de/?utm_source

Federal Cultural Foundation. (n.d.). Funding criteria. From Federal Cultural Foundation: https://www.kulturstiftung-des-bundes.de/en/funding/general_project_funding/funding_criteria.html

Bundeskunstsammlung. (n.d.). Federal Art Collection. From Bundeskunstsammlung: https://www.kunstsammlung-bund.de/?utm_source

National Association for the Visual Arts. (2022). Code of Practice for Visual Arts, Craft and Design. From National Association for the Visual Arts: https://code.visualarts.net.au/?utm_source

FBI. (n.d.). National Stolen Artfile. From FBI: https://artcrimes.fbi.gov/

BildKunst. (n.d.). Collecting society. From BildKunst: https://www.bildkunst.de/ueber_uns/aufgaben/verwertungsgesellschaft/?utm_source